



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ДАШЗЭГВИЙН
АМАРБАЯСГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Аюушийн АРИУНЗАЯА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
<http://www.parliament.mn>

2025 06 19 № УИХ-03/7568

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



А.АРИУНЗАЯА

Ж.АЛДАРЖАВХЛАН

Р.БАТБОЛД

Б.ЖАРГАЛАН

Ч.ЛОДОЙСАМБУУ

Б.НАЙДАЛАА

Н.НОМТОЙБАЯР

У.ОТГОНБАЯР

Х.ТЭМҮҮЖИН

00000000



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Б.БААСАНДОРЖ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Аюушийн АРИУНЗАЯА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
<http://www.parliament.mn>

2025.06.19 № 442-03/7564
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, төслийг хавсаргав.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



А.АРИУНЗАЯА

000000067

БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

А.АРИУНЗАЯА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэж, Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж, Хорин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал үйл ажиллагааныхаа зохих салбар, чиглэлээр Байнгын хороодтой байна.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “... Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт “Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх, хуульд тусгайлан заасан асуудлаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах чиг үүрэгтэй ажиллана.” гэж заасан бөгөөд тус хуульд Улсын Их Хурал нь 11 Байнгын хороотой ажиллахаар тусгасан байна.

Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдан ажилласнаас хойших хугацаанд Улсын Их Хурал 7-11 Байнгын хороотойгоор үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд 1996-2004, 2006-2012 он хүртэл Аюулгүй байдал, гадаад бодлогын; Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн; Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны; Төрийн байгуулалтын; Төсвийн; Хууль зүйн; Эдийн засгийн гэсэн 7 Байнгын хороотойгоор, 2012-2020 он хүртэл эдгээр Байнгын хороод дээр Өргөдлийн байнгын хороог нэмж, 8 Байнгын хороотойгоор ажиллаж байсан.

Монгол Улсын Их Хурал 2020 оноос үйлдвэржилтийн бодлого, ёс зүй, дэгийн асуудал, инновац, цахим бодлогын асуудал эрхэлсэн 3 Байнгын хороог нэмж байгуулан Аж үйлдвэржилтийн бодлогын, Аюулгүй байдал, гадаад бодлогын, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Ёс зүй, дэгийн, Инновац, цахим бодлогын, Нийгмийн бодлогын, Төрийн байгуулалтын, Төсвийн, Хууль зүйн, Эдийн засгийн гэсэн 11 Байнгын хороотой ажиллаж байна. Улсын Их Хурлын 11 Байнгын хороо хуульд заасан эрхлэх асуудлынхаа хүрээнд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийн талаар санал, дүгнэлт гаргах, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй. Байнгын хороодын тоо олон байгаагаас шалтгаалан хэлэлцэх асуудал харилцан адилгүй, ажлын ачаалал өөр өөр байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт Байнгын хороо 25 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар заасан ч өргөн мэдүүлсэн хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэн санал дүгнэлт гаргах, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй зарим Байнгын хороо 11-12 гишүүний

бүрэлдэхүүнтэй буюу хуульд заасан тооны дээд хязгаарын 50 хувьд ч хүрэхээргүй байна.

Иймд Улсын Их Хурлын зохион байгуулалтыг цомхон, үйл ажиллагааг боловсронгуй болгон сайжруулах, бодлогын шийдвэрийг илүү мэргэшсэн байдлаар хэлэлцэн уялдаа холбоотой, нэгдмэл гаргах, Байнгын хороодод харьяалагдах гишүүдийн тоог нэмэгдүүлэх хүрээнд зарим Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээг нэгтгэх, эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дэд хороонд харьяалуулах нь зүйтэй байна. Ингэснээр Улсын Их Хурлын үйл ажиллагааны үр дүнд гарч байгаа хууль тогтоомж, бусад шийдвэр оновчтой байх, зохих салбар, чиглэлээр хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлд Байнгын хорооны харьяанд түүний эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцах үүрэг бүхий дэд хороо байгуулж болох бөгөөд дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд судалгаа хийх, холбогдох мэдээлэл авах, зохих албан тушаалтан, иргэн, байгууллагаас тайлбар авах, ажлын хэсэг байгуулах, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, санал, дүгнэлт гаргаж, түүнийгээ харьяалагдах Байнгын хороонд, шаардлагатай бол Байнгын хороогоор уламжлан нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, эрхэлсэн асуудлаараа тогтоол гаргах эрхтэй байхаар заасан. Улсын Их Хурлын Байнгын хороодын бүрэлдэхүүнд Тусгай хяналтын, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын, Төсвийн зарлагын хяналтын, Хүний эрхийн, Тогтвортой хөгжлийн зорилгын гэсэн 5 дэд хороо ажиллаж байгаа бөгөөд Байнгын хорооны эрхлэх асуудлын цар хүрээ, онцлогоос хамааран Байнгын хорооны эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцаж, асуудлыг мэргэжлийн түвшинд хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж, Улсын Их Хурлаас гаргах шийдвэрийн чанарыг сайжруулах шаардлагыг харгалзан зарим Байнгын хорооны эрхлэх асуудлаар дэд хороодыг байгуулна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, 13.4 дэх хэсэгт нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын үйл ажиллагаа, Улсын Их Хурлын хяналт шалгалтын ажлыг уялдуулан зохицуулах, нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын саналыг харгалзан ээлжит болон ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох, тухайн долоо хоногт чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов, дараалал, хууль тогтоомжийн төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх хугацааг хэлэлцүүлгийн үе шат бүрээр тогтоох, Улсын Их Хурлын төсөв болон Улсын Их Хурлын дотоод үйл ажиллагаатай холбогдолтой бусад асуудлыг зөвшилцөх чиг үүрэг бүхий Зөвлөл ажиллахаар заасан.

Монгол Улсын Их Хурлын сонгууль холимог тогтолцоогоор буюу олныг төлөөлөх /мажоритар/ болон хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорционал/ аргаар явагдах эрх зүйн орчин бүрдсэнтэй холбоотойгоор Улсын Их Хуралд суудалтай нам, эвслийн тоо нэмэгдэж байгаа тул тус Зөвлөлд Монгол Улсын Их Хуралд суудалтай, нам, эвслийн бүлэг байгуулаагүй нам, эвслийн төлөөлөл болох Улсын Их Хурлын гишүүн, нам, эвслийн бүлгийн дэд даргыг оролцуулж, Улсын Их Хуралд суудалтай нам, эвсэл бүрийг мэдээллээр хангах, оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Мөн Улсын Их Хуралд Өргөдлийн байнгын хороог байгуулж, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар иргэдийн өргөдлийн асуудлыг эрхлэх асуудалд тусгаж байгаагаар холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн

өргөдлийг цахимаар хүлээн авах, хэлэлцэхтэй холбогдох зохицуулалтад одоо журмаар зохицуулж байгаа зарим асуудлыг тусган зохицуулахаар байна.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасан хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараах зохицуулалтыг тусгана. Үүнд:

1.Иргэд, байгууллагаас Улсын Их Хуралд ирүүлсэн өргөдлийг судлах, дүн шинжилгээ хийх, холбогдох санал бэлтгэх болон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийн асуудлыг эрхлэх Өргөдлийн байнгын хороог байгуулна;

2.Аж үйлдвэржилтийн бодлогын болон Инновац, цахим бодлогын байнгын хороог Эдийн засгийн байнгын хороонд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороог Нийгмийн бодлогын байнгын хороонд, Ёс зүй, дэгийн байнгын хороог Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус нэгтгэнэ.

Байнгын хороодыг нэгтгэсэнтэй холбоотойгоор Аж үйлдвэржилтийн бодлогын, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Ёс зүй, дэгийн, Инновац, цахим бодлогын байнгын хороотой холбогдох зохицуулалтыг холбогдох байнгын хороодод шилжүүллээ.

Түүнчлэн Байнгын хороодын эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд Ёс зүйн, Бүсчилсэн хөгжлийн; Эдийн засгийн байнгын хороонд Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн, Инновац, цахим бодлогын хөгжлийн; Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд Агаар, орчны бохирдлын, Хүнс, хөдөө аж ахуйн; Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд Шинжлэх ухааны, Соёл, спорт, залуучуудын дэд хороог байгуулна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан Зөвлөлийн хуралд Зөвлөлийн бүрэлдэхүүнээс гадна Монгол Улсын Их Хуралд суудалтай, нам, эвслийн бүлэг байгуулаагүй нам, эвслийн төлөөлөл болох Улсын Их Хурлын гишүүн санал өгөх эрхтэйгээр, нам, эвслийн бүлгийн дэд дарга нар санал өгөх эрхгүйгээр оролцож болохоор тусгана.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6 дахь хэсгийн холбогдох журам батлах зохицуулалтыг хасаж, уг журмаар зохицуулсан зарим асуудлыг хуульд нэмж тусгана.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд орж байгаа дээрх өөрчлөлттэй холбоотойгоор Байнгын хороо 32 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байх, Төрийн

байгуулалтын болон Төсвийн байнгын хорооны бүрэлдэхүүнд Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн хоёроос илүүгүй, бусад Байнгын хорооны бүрэлдэхүүнд гурваас илүүгүй байх, хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсгийн Ёс зүй дэгийн байнгын хорооны тогтоолоор батлах журмыг Төрийн байгуулалтын байнгын хорооны тогтоолоор батлах болон бусад өөрчлөлтүүдийг хуулийн төсөлд тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурлын Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээ оновчтой болж, Улсын Их Хурлын дотоод зохион байгуулалт сайжирна. Мөн Байнгын хороод хууль тогтоомжийг хэлэлцэх, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргээ илүү мэргэшсэн байдлаар хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн. Хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Дэлгэрэнгүй танилцуулга

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэж, Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж, Хорин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал үйл ажиллагааныхаа зохих салбар, чиглэлээр Байнгын хороодтой байна.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “... Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт “Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх, хуульд тусгайлан заасан асуудлаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах чиг үүрэгтэй ажиллана.” гэж заасан бөгөөд тус хуульд Улсын Их Хурал нь 11 Байнгын хороотой ажиллахаар тусгасан байна.

Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдан ажилласнаас хойших хугацаанд Улсын Их Хурал 7-11 Байнгын хороотойгоор үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд 1996-2004, 2006-2012 он хүртэл Аюулгүй байдал, гадаад бодлогын; Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн; Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны; Төрийн байгуулалтын; Төсвийн; Хууль зүйн; Эдийн засгийн гэсэн 7 Байнгын хороотойгоор, 2012-2020 он хүртэл эдгээр Байнгын хороод дээр Өргөдлийн байнгын хороог нэмж, 8 Байнгын хороотойгоор ажиллаж байсан.

Монгол Улсын Их Хурал 2020 оноос үйлдвэржилтийн бодлого, ёс зүй, дэгийн асуудал, инновац, цахим бодлогын асуудал эрхэлсэн 3 Байнгын хороог нэмж байгуулан Аж үйлдвэржилтийн бодлогын, Аюулгүй байдал, гадаад бодлогын, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Ёс зүй, дэгийн, Инновац, цахим бодлогын, Нийгмийн бодлогын, Төрийн байгуулалтын, Төсвийн, Хууль зүйн, Эдийн засгийн гэсэн 11 Байнгын хороотой ажиллаж байна. Улсын Их Хурлын 11 Байнгын хороо хуульд заасан эрхлэх асуудлынхаа хүрээнд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийн талаар санал, дүгнэлт гаргах, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй. Байнгын хороодын тоо олон байгаагаас шалтгаалан хэлэлцэх асуудал харилцан адилгүй, ажлын ачаалал өөр өөр байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт Байнгын хороо 25 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар заасан ч өргөн мэдүүлсэн хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэн санал дүгнэлт гаргах, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй зарим Байнгын хороо 11-12 гишүүний бүрэлдэхүүнтэй буюу хуульд заасан тооны дээд хязгаарын 50 хувьд ч хүрэхээргүй байна.

Иймд Улсын Их Хурлын зохион байгуулалтыг цомхон, үйл ажиллагааг боловсронгуй болгон сайжруулах, бодлогын шийдвэрийг илүү мэргэшсэн байдлаар хэлэлцэн уялдаа холбоотой, нэгдмэл гаргах, Байнгын хороодод харьяалагдах

гишүүдийн тоог нэмэгдүүлэх хүрээнд зарим Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээг нэгтгэх, эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дэд хороонд харьяалуулах нь зүйтэй байна. Ингэснээр Улсын Их Хурлын үйл ажиллагааны үр дүнд гарч байгаа хууль тогтоомж, бусад шийдвэр оновчтой байх, зохих салбар, чиглэлээр хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлд Байнгын хорооны харьяанд түүний эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцах үүрэг бүхий дэд хороо байгуулж болох бөгөөд дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд судалгаа хийх, холбогдох мэдээлэл авах, зохих албан тушаалтан, иргэн, байгууллагаас тайлбар авах, ажлын хэсэг байгуулах, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, санал, дүгнэлт гаргаж, түүнийгээ харьяалагдах Байнгын хороонд, шаардлагатай бол Байнгын хороогоор уламжлан нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, эрхэлсэн асуудлаараа тогтоол гаргах эрхтэй байхаар заасан. Улсын Их Хурлын Байнгын хороодын бүрэлдэхүүнд Тусгай хяналтын, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын, Төсвийн зарлагын хяналтын, Хүний эрхийн, Тогтвортой хөгжлийн зорилгын гэсэн 5 дэд хороо ажиллаж байгаа бөгөөд Байнгын хорооны эрхлэх асуудлын цар хүрээ, онцлогоос хамааран Байнгын хорооны эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцаж, асуудлыг мэргэжлийн түвшинд хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж, Улсын Их Хурлаас гаргах шийдвэрийн чанарыг сайжруулах шаардлагыг харгалзан зарим Байнгын хорооны эрхлэх асуудлаар дэд хороодыг байгуулна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, 13.4 дэх хэсэгт нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын үйл ажиллагаа, Улсын Их Хурлын хяналт шалгалтын ажлыг уялдуулан зохицуулах, нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын саналыг харгалзан ээлжит болон ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох, тухайн долоо хоногт чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов, дараалал, хууль тогтоомжийн төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх хугацааг хэлэлцүүлгийн үе шат бүрээр тогтоох, Улсын Их Хурлын төсөв болон Улсын Их Хурлын дотоод үйл ажиллагаатай холбогдолтой бусад асуудлыг зөвшилцөх чиг үүрэг бүхий Зөвлөл ажиллахаар заасан.

Монгол Улсын Их Хурлын сонгууль холимог тогтолцоогоор буюу олныг төлөөлөх /мажоритар/ болон хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорционал/ аргаар явагдах эрх зүйн орчин бүрдсэнтэй холбоотойгоор Улсын Их Хуралд суудалтай нам, эвслийн тоо нэмэгдэж байгаа тул тус Зөвлөлд Монгол Улсын Их Хуралд суудалтай, нам, эвслийн бүлэг байгуулаагүй нам, эвслийн төлөөлөл болох Улсын Их Хурлын гишүүн, нам, эвслийн бүлгийн дэд даргыг оролцуулж, Улсын Их Хуралд суудалтай нам, эвсэл бүрийг мэдээллээр хангах, оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Мөн Улсын Их Хуралд Өргөдлийн байнгын хороог байгуулж, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар иргэдийн өргөдлийн асуудлыг эрхлэх асуудалд тусгаж байгаатай холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг цахимаар хүлээн авах, хэлэлцэхтэй холбогдох зохицуулалтад одоо журмаар зохицуулж байгаа зарим асуудлыг тусган зохицуулахаар байна.

Эдгээр үндэслэл, шаардлагыг харгалзан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа. Хуулийн төсөл 6 зүйлтэй.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараах зохицуулалтыг тусгалаа. Үүнд:

1.Иргэд, байгууллагаас Улсын Их Хуралд ирүүлсэн өргөдлийг судлах, дүн шинжилгээ хийх, холбогдох санал бэлтгэх болон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийн асуудлыг эрхлэх Өргөдлийн байнгын хороог байгуулна;

2.Аж үйлдвэржилтийн бодлогын болон Инновац, цахим бодлогын байнгын хороог Эдийн засгийн байнгын хороонд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороог Нийгмийн бодлогын байнгын хороонд, Ёс зүй, дэгийн байнгын хороог Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус нэгтгэнэ.

Байнгын хороодын эрхлэх асуудлыг нэгтгэсэнтэй холбоотойгоор Аж үйлдвэржилтийн бодлогын, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Ёс зүй, дэгийн, Инновац, цахим бодлогын байнгын хороотой холбогдох зохицуулалтыг холбогдох Байнгын хороодод шилжүүлэхээр тусгалаа.

Түүнчлэн Байнгын хороодын эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд Ёс зүйн, Бүсчилсэн хөгжлийн; Эдийн засгийн байнгын хороонд Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн, Инновац, цахим бодлогын хөгжлийн; Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд Агаар, орчны бохирдлын, Хүнс, хөдөө аж ахуйн; Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд Шинжлэх ухааны, Соёл, спорт, залуучуудын дэд хороог байгуулахаар тусгагдсан болно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан Зөвлөлийн хуралд Зөвлөлийн бүрэлдэхүүнээс гадна Монгол Улсын Их Хуралд суудалтай, нам, эвслийн бүлэг байгуулаагүй нам, эвслийн төлөөлөл болох Улсын Их Хурлын гишүүн санал өгөх эрхтэйгээр, нам, эвслийн бүлгийн дэд дарга нар санал өгөх эрхгүйгээр оролцож болохоор тусгалаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6 дахь хэсгийн холбогдох журам батлах зохицуулалтыг хасаж, уг журмаар зохицуулсан зарим асуудлыг хуульд нэмж тусгасан болно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд орж байгаа дээрх өөрчлөлтэй холбоотойгоор Байнгын хороо 32 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байх, Төрийн байгуулалтын болон Төсвийн байнгын хорооны бүрэлдэхүүнд Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн хоёроос илүүгүй, бусад Байнгын хорооны бүрэлдэхүүнд гурваас илүүгүй байх, хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсгийн Ёс зүй дэгийн байнгын хорооны тогтоолоор батлах журмыг Төрийн байгуулалтын байнгын хорооны тогтоолоор батлах болон бусад өөрчлөлтүүдийг хуулийн төсөлд тусгалаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсрууллаа.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал үйл ажиллагааныхаа зохих салбар, чиглэлээр Байнгын хороодтой байна.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “... Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт “Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх, хуульд тусгайлан заасан асуудлаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах чиг үүрэгтэй ажиллана.” гэж заасан бөгөөд тус хуульд Улсын Их Хурал нь 11 Байнгын хороотойгоор ажиллахаар тусгасан байна.

Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдан ажилласнаас хойших хугацаанд Улсын Их Хурал 7-11 Байнгын хороотойгоор үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд 1996-2004, 2006-2012 он хүртэл Аюулгүй байдал, гадаад бодлогын; Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн; Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны; Төрийн байгуулалтын; Төсвийн; Хууль зүйн; Эдийн засгийн гэсэн 7 Байнгын хороотойгоор, 2012-2020 он хүртэл эдгээр Байнгын хороод дээр Өргөдлийн байнгын хороог нэмж, 8 Байнгын хороотойгоор ажиллаж байсан.

Монгол Улсын Их Хурал 2020 оноос үйлдвэржилтийн бодлого, ёс зүй, дэгийн асуудал, инновац, цахим бодлогын асуудал эрхэлсэн 3 Байнгын хороог нэмж байгуулан Аж үйлдвэржилтийн бодлогын, Аюулгүй байдал, гадаад бодлогын, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Ёс зүй, дэгийн, Инновац, цахим бодлогын, Нийгмийн бодлогын, Төрийн байгуулалтын, Төсвийн, Хууль зүйн, Эдийн засгийн гэсэн 11 Байнгын хороотой ажиллаж байна. Улсын Их Хурлын 11 Байнгын хороо хуульд заасан эрхлэх асуудлынхаа хүрээнд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийн талаар санал, дүгнэлт гаргах, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй. Байнгын хороодын тоо олон байгаагаас шалтгаалан хэлэлцэх асуудал харилцан адилгүй, ажлын ачаалал өөр өөр байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт Байнгын хороо 25 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар заасан ч өргөн мэдүүлсэн хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэн санал дүгнэлт гаргах, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй зарим Байнгын хороо 11-12 гишүүний бүрэлдэхүүнтэй буюу хуульд заасан тооны дээд хязгаарын 50 хувьд ч хүрэхээргүй байна.

Иймд Улсын Их Хурлын зохион байгуулалтыг цомхон, үйл ажиллагааг боловсронгуй болгон сайжруулах, бодлогын шийдвэрийг илүү мэргэшсэн байдлаар хэлэлцэн уялдаа холбоотой, нэгдмэл гаргах, Байнгын хороодод харьяалагдах гишүүдийн тоог нэмэгдүүлэх хүрээнд зарим Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээг нэгтгэх, эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дэд хороонд харьяалуулах нь зүйтэй байна. Ингэснээр Улсын Их Хурлын үйл ажиллагааны үр дүнд гарч байгаа хууль тогтоомж, бусад шийдвэр оновчтой байх, зохих салбар, чиглэлээр хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Тиймээс иргэд, байгууллагаас Улсын Их Хуралд ирүүлсэн өргөдлийг судлах, дүн шинжилгээ хийх, холбогдох санал бэлтгэх болон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийн асуудлыг эрхлэх Өргөдлийн байнгын хороог байгуулах, Аж үйлдвэржилтийн бодлогын болон Инновац, цахим бодлогын байнгын хороог Эдийн засгийн байнгын хороонд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороог Нийгмийн бодлогын байнгын хороонд, Ёс зүй, дэгийн байнгын хороог Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус нэгтгэхээр төсөлд тусгалаа.

2. Байнгын хороодын эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд Ёс зүйн, Бүсчилсэн хөгжлийн; Эдийн засгийн байнгын хороонд Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн, Инновац, цахим бодлогын хөгжлийн; Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд Агаар, орчны бохирдлын, Хүнс, хөдөө аж ахуйн; Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд Шинжлэх ухааны, Соёл, спорт, залуучуудын дэд хороог байгуулахаар тусгалаа.

3. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлд нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын үйл ажиллагаа, Улсын Их Хурлын хяналт шалгалтын ажлыг уялдуулан зохицуулах, нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын саналыг харгалзан ээлжит болон ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох, тухайн долоо хоногт чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов, дараалал, хууль тогтоомжийн төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх хугацааг хэлэлцүүлгийн үе шат бүрээр тогтоох, Улсын Их Хурлын төсөв болон Улсын Их Хурлын дотоод үйл ажиллагаатай холбогдолтой бусад асуудлыг зөвшилцөх чиг үүрэг бүхий Зөвлөл ажиллахаар заасан.

Монгол Улсын Их Хурлын сонгууль холимог тогтолцоогоор явагдах эрх зүйн орчин бүрдсэнтэй холбоотойгоор Улсын Их Хуралд суудалтай нам, эвслийн тоо нэмэгдэж байгаа бөгөөд Улсын Их Хуралд суудалтай нам, эвсэл бүрийн төлөөллийг тус Зөвлөлд багтаан мэдээллээр хангах, оролцоог нэмэгдүүлэх шаардлагыг харгалзан Зөвлөлийн хуралд Зөвлөлийн бүрэлдэхүүнээс гадна Монгол Улсын Их Хуралд суудалтай, нам, эвслийн бүлэг байгуулаагүй нам, эвслийн төлөөлөл болох Улсын Их Хурлын гишүүн санал өгөх эрхтэйгээр, нам, эвслийн бүлгийн дэд дарга нар санал өгөх эрхгүйгээр оролцож болохоор тусгалаа.

4. Улсын Их Хуралд Өргөдлийн байнгын хороог байгуулж, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар иргэдийн өргөдлийн асуудлыг эрхлэх асуудалд тусгаж байгаатай холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6 дахь хэсгийн холбогдох журам батлах зохицуулалтыг хасаж, уг журмаар зохицуулсан зарим асуудлыг хуульд нэмж тусгасан болно.

5. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд орж байгаа дээрх өөрчлөлтэй холбоотойгоор Байнгын хороо 32 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байх, Төрийн байгуулалтын болон Төсвийн байнгын хорооны бүрэлдэхүүнд Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн хоёроос илүүгүй, бусад Байнгын хорооны бүрэлдэхүүнд гурваас илүүгүй байх, хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсгийн Ёс зүй дэгийн байнгын хорооны тогтоолоор батлах журмыг Төрийн байгуулалтын байнгын хорооны тогтоолоор батлах болон бусад өөрчлөлтүүдийг хуулийн төсөлд тусгалаа.

6.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

----oOo----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэг:

“13.5.Зөвлөлийн хуралд нам, эвслийн бүлгийн дэд дарга таслах эрхгүйгээр оролцох бөгөөд холбогдох албан тушаалтныг байлцуулж болно.”

2/22 дугаар зүйлийн 22.6.8 дахь заалт:

“22.6.8.Өргөдлийн;”

3/23 дугаар зүйлийн 23.8 дахь хэсэг:

“23.8.Өргөдлийн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:

23.8.1.иргэн, байгууллагаас Улсын Их Хурал, түүний Байнгын, дэд, хянан шалгах түр хороо, тэдгээрийн удирдлага, гишүүнд ирүүлсэн өргөдлийг судлах, дүн шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороонд санал хүргүүлэх, мэдээлэх;

23.8.2.нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийн асуудал.”

4/23 дугаар зүйлийн 23.8.17-23.8.21 дэх заалт:

“23.8.17.гишүүний ёс зүй, сахилгын асуудал;

23.8.18.гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлэг;

23.8.19.Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэх гишүүний чуулганы ажиллагаанд оролцох асуудал;

23.8.20.чуулганы хуралдааны дэгийн асуудал, дэг сахиулах;

23.8.21.төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлагын бодлого.”

5/23 дугаар зүйлийн 23.11.21-23.11.30 дахь заалт:

“23.11.21.жигжиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлого;

23.11.22.хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлого;

23.11.23.хүнд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлого;

23.11.24.цахим засаглалын бодлого, үйл ажиллагаа;
23.11.25.мэдээллийн технологийн хөгжил;
23.11.26.харилцаа холбооны бодлого, үйл ажиллагаа;
23.11.27.дигитал шилжилт, техник, технологийн шинэчлэл;
23.11.28.өндөр технологи, үндэсний инновацын бодлого;
23.11.29.инновацыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлж эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн оролцоог дэмжих бодлого;

23.11.30.инновацын дэд бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг хөгжүүлэх бодлого.”

6/39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсэг:

“39.4.Нийтийн өргөдөл гаргахад дараах шаардлагыг хангасан байна:

39.4.1.өргөдөл гаргагч 18 насанд хүрсэн байх;
39.4.2.өргөдөлд хүний хувийн мэдээлэл агуулаагүй байх;
39.4.3.өргөдлийг монгол хэлээр, кирил үсгээр бичсэн байх;
39.4.4.өргөдлийн агуулга, ойлгомжтой тодорхой байх;
39.4.5.бусдыг гүтгэх, доромжлох, гутаах агуулга, ёс бус үг, хэллэг хэрэглээгүй байх;

39.4.6.өргөдлийг тодорхой нэг асуудлаар гаргах бөгөөд өөр агуулга тусгахаар бол тусад нь өргөдөл гаргах.”

2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “Байнгын хороодын дарга,” гэсний дараа “Улсын Их Хуралд суудалтай бөгөөд нам, эвслийн бүлэг байгуулаагүй нам, эвслийн төлөөлөл болох гишүүн,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/22 дугаар зүйлийн 22.6.7 дахь заалт:

“22.6.7.Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны;”

2/23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсэг:

“23.7.Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:

23.7.1.боловсрол;
23.7.2.жендэрийн тэгш байдлыг хангах бодлого;
23.7.3.монгол хэл, бичиг, үндэсний цөөнхийн хэл, бичиг, ёс заншил;
23.7.4.мэргэжлийн боловсрол, сургалт;
23.7.5.нийгмийн хамгаалал, нийгмийн даатгал, халамжийн бодлого;
23.7.6.нийтийн биеийн тамир, спорт;

23.7.7.түүх, соёл, оюуны өвийг хамгаалах, сэргээх бодлого;
23.7.8.соёл, урлаг;
23.7.9.хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн харилцаа;
23.7.10.хүн амын хөгжлийн бодлого;
23.7.11.шинжлэх ухаан;
23.7.12.эрүүл мэндийн бодлого.”

3/25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсэг:

“25.5.Төрийн байгуулалтын байнгын хорооны болон Төсвийн байнгын хорооны бүрэлдэхүүнд Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн хоёроос илүүгүй, бусад Байнгын хорооны бүрэлдэхүүнд гурваас илүүгүй байна.”

4/27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг:

“27.3.Улсын Их Хурал Байнгын хорооны бүрэлдэхүүнд дараах дэд хороог байгуулна:

27.3.1.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Тусгай хяналтын;

27.3.2.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд Агаар, орчны бохирдлын, Хүнс, хөдөө аж ахуйн;

27.3.3.Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд Соёл, спорт, залуучуудын, Шинжлэх ухааны;

27.3.4.Төрийн байгуулалтын байнгын хороонд Бүсчилсэн хөгжлийн, Ёс зүйн, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын;

27.3.5.Төсвийн байнгын хороонд Төсвийн зарлагын хяналтын;

27.3.6.Хууль зүйн байнгын хороонд Хүний эрхийн;

27.3.7.Эдийн засгийн байнгын хороонд Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн, Инновац, цахим бодлогын хөгжлийн, Тогтвортой хөгжлийн зорилгын.”

5/27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсэг:

“27.5.Энэ хуулийн 27.3-т заасан дэд хороо дараах асуудлыг эрхэлнэ:

27.5.1.Агаар, орчны бохирдлын дэд хороо агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах асуудлаарх бодлогын асуудлыг;

27.5.2.Бүсчилсэн хөгжлийн дэд хороо бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс, орон нутгийн хөгжлийн асуудлыг;

27.5.3.Ёс зүйн дэд хороо гишүүний ёс зүй, сахилга, хөрөнгө, орлогын мэдүүлэг, чуулганы хуралдааны дэг сахиулах асуудлыг;

27.5.4.Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжлийн бодлогын асуудлыг;

27.5.5.Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хороо өндөр технологи, үндэсний инновацыг дэмжих, хөгжүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, цахим хөгжлийн бодлогын асуудлыг;

27.5.6.Соёл, спорт, залуучуудын дэд хороо соёл, урлаг, түүх, соёл, оюуны өвийг хамгаалах, сэргээх бодлого, нийтийн биеийн тамир, спортын асуудлыг;

27.5.7.Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилгуудыг хууль тогтоомж болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгах, хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг;

27.5.8.Төсвийн зарлагын хяналтын дэд хороо улсын болон орон нутгийн төсвийн орлого, зарлага, төсвийн хяналтын асуудлыг;

27.5.9.Тусгай хяналтын дэд хороо төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, тагнуул болон гүйцэтгэх ажлын талаарх хууль тогтоомжийн биелэлт, улсын хил хамгаалалт, төрийн тусгай хамгаалалтын асуудлыг;

27.5.10.Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо гишүүний халдашгүй байдал, бүрэн эрхтэй холбогдсон асуудлыг;

27.5.11.Хүний эрхийн дэд хороо хүний эрх, эрх чөлөөний баталгаа, өршөөл, цагаачлал, иргэний харьяаллын бодлогын асуудлыг;

27.5.12.Хүнс, хөдөө аж ахуйн дэд хороо хүнс, хөдөө аж ахуйн бодлого, хөтөлбөр, хөдөө аж ахуйн хоршооны асуудлыг;

27.5.13.Шинжлэх ухааны дэд хороо шинжлэх ухааны нэгдсэн бодлогын асуудлыг.”

4 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “25” гэснийг “32” гэж, 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсгийн “Ёс зүй, дэгийн” гэснийг “Төрийн байгуулалтын” гэж, 23 дугаар зүйлийн 23.11.4 дэх заалтын “23.9.8-д” гэснийг “23.10.8-д” гэж, 13 дугаар зүйлийн 13.5-13.7 дахь хэсгийн дугаарыг “13.6-13.8” гэж, 22 дугаар зүйлийн 22.6.8-22.6.11 дэх заалтын дугаарыг “22.6.9-22.6.12” гэж, 23 дугаар зүйлийн 23.8-23.11 дэх хэсгийн дугаарыг “23.9-23.12” гэж, 39 дүгээр зүйлийн 39.4-39.6 дахь хэсгийн дугаарыг “39.5-39.7” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “Зөвлөлийн хуралдаанд холбогдох албан тушаалтныг байлцуулж болно.” гэсэн хоёр дахь өгүүлбэрийг хассугай.

6 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.1, 22.6.4-22.6.6 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.1, 23.4-23.6 дахь хэсэг, 39 дүгээр

зүйлийн 39.7 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.5.23 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ
ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15.10 дахь хэсгийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн, 16.2 дахь хэсгийн, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн, 115 дугаар зүйлийн 115.2.14 дэх заалтын “Ёс зүй, дэгийн” гэснийг “Төрийн байгуулалтын” гэж, 95 дугаар зүйлийн 95.2 дахь хэсгийн “39.4-т” гэснийг “39.5-д” гэж, 115 дугаар зүйлийн 115.2.8, 115.2.12, 115.2.16 дахь заалтын “Нийгмийн бодлогын” гэснийг “Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг